

**Хүний эрхийн хамгаалагчдын Үндэсний 4-р зөвлөгөөн:
“Хүний эрх, хөгжлийг хөхиүлэн дэмжих нь”**

Улаанбаатар хот, 2018 оны 11-р сарын 12-15

Зохион байгуулагчид:
Хүний Эрх Хөгжил Төв (ХЭХТ)
Глоб Интернэшнл (ГИ)
Хүний Эрх, Хөгжлийн Азийн Форум (ФОРУМ-АЗИ)
(Зүүн Ази болон АСЕАН, Хүний Эрхийг Хамгаалагчдын Хөтөлбөр)

Нөхцөл байдал

Монгол улс 1990 онд ардчилсан нийгэмд шилжиж олон намын системийг байгуулснаас хойшхи өнгөрсөн хугацаанд сонгуулийг амжилттай зохион байгуулж, олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрүүдийг баталсан хэдий ч санаа зовоосон асуудлууд байсан хэвээр байна. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр голлох улс төрийн намууд үндсэрхэг үзлийг хүчтэй гаргаж ирсэн. Улс төрийн сонголтондоо сэтгэл хангалуун биш, үзэл баримтлалд суурилсан улс төрийн намгүй учир Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураах үеэр Монголын олон иргэд саналын хоосон хуудас өгсөн. Түдгэлзсэн сонгогчдын тоо сүүлийн арав гаруй жилийн хугацаанд огцом нэмэгдсэн бөгөөд 2000 оны УИХ-ын сонгуулийн сонгогчдын ирц 82,43% байсан бол 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар 60,67%-тай болж буурчээ¹. Энэхүү огцом бууралт нь улс төрийн намууд ард иргэдтэй харилцдаггүй, холбоо хамааралгүй болсноос үүдсэн байх магадлалтай.

Хүний эрхийн голлох зөрчлүүдэд анхаарал хандуулах шаардлагатай байгаа бөгөөд үүнд иргэний болон улс төрийн эрхийн асуудлууд, тухайлбал, эмэгтэй/хүний эрхийг хамгаалагчид хуулийн хамгаалалтгүй, эмэгтэй/хүний эрхийг хамгаалагчдын гүйцэтгэх үүргийн талаар ард иргэд мэдлэг мэдээлэлгүй, олборлох салбарын байгаль орчны шударга байдал, газар эзэмших эрхэд үзүүлэх нөлөө, жендерийн эрх тэгш байдал болон эмэгтэйчүүдийн эрх, ядуурал болон хоол хүнсний хараат бус байдал зэрэг багтаж байгаа юм. Ажил үүргээ гүйцэтгэж буй эрхийг хамгаалагчид төр болон төрийн бус субъектуудын заналхийлэл, айлган сүрдүүлэг, дайралтанд өртсөөр байгааг дурьдах нь зүйтэй. Мөн улсын хэмжээнд, бизнесийн байгууллагууд хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөллийнхөө хариуцлагыг хүлээдэг байх тогтолцоог нэн яаралтай бий болгох шаардлага үүсээд байна.

Эдгээр асуудалд анхаарал хандуулах зорилгоор Хүний эрх болон Хөгжлийн Азийн Форум (ФОРУМ-АЗИ), гишүүн байгууллага Хүний эрх хөгжил төв, Глоб интернейшнл ТББ-уудтай хамтран 2015-2017 оны хугацаанд үзэл бодлоо илэрхийлэх эрх, орон нутгийн иргэдийн байгаль орчны эрх, эмэгтэй/хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах механизм, бизнесийн болон хөгжлийн томоохон төслүүдийн сөрөг нөлөө зэрэг асуудлыг хөндсөн өмгөөлөл, ур чадвар хөгжүүлэх зорилгоор жил бүр Хүний эрхийн хамгаалагчдын Үндэсний зөвлөгөөн зохион байгуулсан бөгөөд энэ жил дөрөв дэх удаагаа зохион байгуулж байна.

Өмнөх зөвлөгөөнүүдийн үеэр Монгол улсад хүний эрхийг хамгаалагчид үйл ажиллагаагаа айдас, сүрдүүлэг, доромжлолгүйгээр хийх эрхзүйн орчин байхгүй байгаа нь онцгойлон анхаарах асуудал гэж тодорхойлсон. Нөхцөл байдлыг өөрчлөхийн тулд хүчин төгөлдөр байгаа эрх зүйн орчныг өөрчлөх, ингэснээр Монгол улсад хүний эрхийг хамгаалагч нарыг хүлээн зөвшөөрөх, тэднийг хамгаалах боломж бүрдэнэ гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

¹ <http://www.electionguide.org/countries/id/144/>

Түүнчлэн, 2017 оны 9-р сард зохион байгуулсан 3-р зөвлөгөөнөөр улс төрийн намууд, Хүний эрхийн Үндэсний Комисс, иргэний нийгмийн байгууллагууд, хүний эрхийг хамгаалагчид, тэдний сүлжээний төлөөлөгчидтэй уулзаж хүний эрхийн асуудлыг байгаль орчин, ашигт малтмал, хүнс, хүн ам, хүүхэд хамгаалал зэрэг салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан хэлэлцүүлэг-ярилцлага зохион байгуулсан болно.

Эдгээр хэлэлцүүлэг-ярилцлагын үр дүнгээс улс төрийн намууд, Хүний эрхийн Үндэсний Комисс-т тодорхой зөвлөмжүүдийг өгсний дотор иргэний нийгмийн байгууллагууд болон улс төрийн намуудын хоорондын харилцааг бататгах, талуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүний эрхийн боловсролыг хөгжүүлэх, цаазын ялыг хүчингүй болгох, эрүүдэн шүүлтийг таслан зогсоох, хүүхдийн эрх, бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, нэн ялангуяа эмэгтэйчүүд болон нийгмээс шоовдорлосон бусад хүмүүсийг ялгаварлан гадуурхахыг зогсоох, эдийн засаг, нийгэм, соёлын эрх, үүний дотор хүнсний хараат бус, баталгаат байдлыг хангах, ядуурлыг арилгах, эмэгтэйчүүдийн эрхийг хэрэгжүүлэх, бизнес болон хүний эрх, ялангуяа уул уурхай, хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн томоохон төслүүдтэй холбоотой асуудлуудыг хөндсөн.

Иргэний нийгмийн байгууллагууд хүний эрхийн гол асуудлуудыг цаашид анхааран авч үзэхдээ Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг эхлэлийн цэг болгон ашиглах шаардлагатай гэж онцгойлон тодорхойлсон. 2017 онд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнд улс төрийн намууд Монгол улсын хүний эрхийн байгууллагуудтай тогтмол уулзах, улс төрийн намын бүтэц дотроо хүний эрхийн механизмыг бүрдүүлнэ гэсэн амлалт өгсөн юм.

Өнгөрсөн жил гүйцэтгэсэн ажлын үр дүн болон Монгол улс дахь хүний эрхийн хамгаалагчдын үндэсний сүлжээг бэхжүүлэх зорилгоор ФОРУМ-АЗИ байгууллага Монгол улс дахь өөрийн гишүүн байгууллагуудын хамтаар 2018 оны 11-р сарын 12-15-ны өдрүүдэд өмгөөлөл болон ур чадварыг хөгжүүлэх 4-р зөвлөгөөнийг зохион байгуулах гэж байна.

4-р зөвлөгөөний зорилтууд:

1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах үндсэн суурь эрхийг хязгаарлаж буй эрхзүйн өөрчлөлтүүд дээр өгсөн зөвлөмжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (тухайлбал, зөрчлийн хууль, гүтгэлгийн хууль гэх мэт);
2. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хуулийн төсөл, гүтгэлгийн эсрэг хуулинд оруулах нэмэлт өөрчлөлтөөр нөлөөллийн стратеги боловсруулах;
3. Хүний эрх хамгаалагчдын үндэсний сүлжээг бэхжүүлэх иргэний нийгмийн байгууллагууд болон хүний эрхийн хамгаалагчдын хөрөнгө, нөөц дайчлах мэдлэг, туршлага, ур чадварыг сайжруулах;
4. Бусад улс орны иргэний нийгмийн байгууллагууд Бизнес ба Хүний эрхийн Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болохын тулд хэрхэн ажилладаг туршлагаас хуваалцах

Хүлээгдэж буй гол үр дүн:

1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх, хүний эрхийг хамгаалагчид болон бизнес, хүний эрхтэй холбоотой гаргасан зөвлөмжүүдийг эргэн хянаж сайжруулсан байх
2. Гүтгэлгийн хуулийг судалж үнэлэх, зөвлөмж гаргах, нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулах
3. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хуулийн төслийг судлах, үнэлэх болон хуулийг батлахтай холбоотой нөлөөллийн стратеги боловсруулах
4. Хүний эрхийг хамгаалагчдын үндэсний сүлжээнд зориулан нөөц боломжийг дайчлах үйл ажиллагааны төлөвлөгөө (2019-2020)
5. Монгол улс дахь хүний эрхийг хамгаалагчдын үндэсний сүлжээг бэхжүүлэх төслийн санал

Оролцогчид

- Үзэл бодлоо илэрхийлэх эрх, гүтгэлгийн хууль, хүний эрхийн хамгаалагчдын хуулийн шинжилгээ, нөөц боломжийг дайчлах чиглэлээр мэргэшсэн шинжээчид
- ФОРУМ-АЗИ-ийн Зүүн Ази-АСЕАН, Хүний эрхийг хамгаалагчид болон Шинэ санаачлагуудын хөтөлбөрийн ажилтнууд
- Зөвлөлдөх уулзалтанд залуучууд, ахмад настнууд, иргэний нийгмийн төлөөлөл оролцож залуучууд болон ахмтад настнуудад тулгарч буй асуудлыг ярилцаж өөрсдийн үзэл бодлоо хуваалцана (Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл болох 50 хүнийг урьж оролцуулна)

Зөвлөгөөний өмнө хийх бэлтгэл ажил

- Хүний эрхийг хамгаалагчийн тухай хуулийн төслийн үнэлгээ шинжилгээ
- Улс төрийн намуудад өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийн талаарх шинэчилсэн мэдээлэл, судалгаа
- Өмнөх зөвлөлдөх уулзалт-хэлэлцүүлгээс (2015-2017) гаргасан ажлын төлөвлөгөө, зөвлөмжүүдээр боловсруулсан хүний эрхийг хамгаалагчдын үндэсний сүлжээний төслийн санал
- Нөөц бололцоог дайчлан ашиглах зөвлөгөөнүүд/баримт бичгүүд
- Хүний эрхийг хамгаалагчдын сүлжээний үндэсний төслийг дэмжих элчин сайдын яамдууд болон боломжит доноруудын талаарх судалгаа
- НҮБ-ийн Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалыг орчуулан түгээх зорилгоор хэвлүүлэх

Хөтөлбөр

Хүний эрхийн хамгаалагчдын Үндэсний 4-р зөвлөгөөн: “Хүний эрх, хөгжлийг хөхиүлэн дэмжих нь” Улаанбаатар, 2018 оны 11-р сарын 12-15		
Өдөр 1, 11-р сарын 12		
08:30 – 09:00	Бүртгэл	
09:00 – 10:20	Нээлт Танилцуулга	Хөтлөгч: Г.Уранцоож (ХЭХТ) <ul style="list-style-type: none">• ХЭҮК-ийн дарга Ж.Бямбадорж• Сежин Ким, ФОРУМ-АЗИ• Х.Наранжаргал, ГИ
10:20 – 10:30	Зураг татуулах	
10:30 - 10:45	Цайны завсарлага	
10:45 – 12:00	Өмнөх дүгнэлт/ Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эмэгтэй/хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, Бизнес ба Хүний эрхийн чиглэлээр гаргасан өмнөх зөвлөмжүүд, ажлын төлөвлөгөөний үнэлгээ - Үндсэн үр дүн, хэрэгжилтийн үнэлгээ, асуудлууд, дараагийн алхмууд, оролцогчид	ФА/ХЭХТ/ГИ удирдан явуулна Илтгэгч Жой Анне Икаян (ФА)
12:00 – 13:00	Өдрийн хоол	
13:00 – 14:30	Хуулийн Гүтгэлэг гэсэн зүйл анги болон Олон улсын гэрээ хэлэлцээрүүдтэй эрх зүйн хувьд нийцэж буй эсэх талаар ярилцах (Бодлогын өөрчлөлт сэдвээр) - Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн Монгол дахь нөхцөл байдал (Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаар Хүний эрхийг хамгаалагчдын 2017 оны зөвлөлдөх уулзалтаас гаргасан дүгнэлтийг хөндөх) - Үзэл бодлоо илэрхийлэх чиглэлээр мэргэшсэн шинжээч Гүтгэлгийн тухай хууль болон олон улсын гэрээ хэлэлцээрийг харьцуулсан танилцуулга болон өмгөөллийн саналууд	Идэвхжүүлэгч: Ц. Мөнхжин (ГИ) Илтгэгч <ul style="list-style-type: none">• Нөхцөл байдал: Х. Наранжаргал (ГИ)• Олон улсын стандартад суурилсан үнэлгээ: Син Йею Нью (Малайз) Урилгаар оролцох: Монголын хуульчдын холбоо
14:30-14:45	Цайны завсарлага	

14:45 – 16:00	Гүтгэлгийн хэргүүд болон олон улсын гэрээнүүдийн үндэслэлийн тухай хэлэлцүүлгийн үргэлжлэл	
16:00-17:00	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх дээр өгөх зөвлөмж - Гүтгэлэгтэй холбоотой зүйл заалтыг лоббидох ажлын төлөвлөгөө (боломж/ эрх олгогчид, хугацаа)	Идэвхжүүлэгч: Х. Наранжаргал (ГИ)
Өдөр 2, 11-р сарын 13		
09:00– 10:30	Хүний эрхийг хамгаалагчдын хуулийн төслийн хэлэлцүүлэг - 2017 оны нөлөөллийн стратегийг дүгнэх нь - Хуулийн төслөөр хийх нөлөөллийн ажлын төлөвлөгөө (боломж/эрх олгогчид, хугацаа г.м.)	Идэвхжүүлэгч: Г.Уранцоож (ХЭХТ) Илтгэгч • Өмнө боловсруулсан стратеги, бусад улсын туршлага: Сежин Ким (ФА) • ХЭХ-ийн хуулийн ажлын хэсэг
10:30 – 10:45	Цайны завсарлага	
10:45 – 13:00	Хэлэлцүүлэг үргэлжилнэ.	Урилгаар оролцох: Хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээ хийсэн судлаачдын баг
13:00 – 14:00	Өдрийн хоол	
14:00 – 16:00	Бизнес болон Хүний эрхийн талаарх арга хэмжээний үндэсний төлөвлөгөө - 2017 онд гаргаж ирсэн Бизнес ба хүний эрхийн асуудлууд, сүүлийн үеийн үйл явдлуудыг нэгтгэн дүгнэх - Бизнес ба Хүний эрх Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх шаардлага, ач холбогдол (үүрэг, яагаад чухал гэж) - Туршлагаа хуваалцъя: иргэний нийгмийн байгууллагуудын Бизнес ба Хүний эрх-ийг Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнд оруулсан Өмнөд Солонгос ба Тайландын туршлага	Идэвхжүүлэгч: У.Мандхайцэцэн (ХЭХТ) Илтгэгч • Лорензо Урбинати (ФА)
16:00 – 16:15	Цайны завсарлага	
16:15 – 18:00	- Бизнес ба Хүний эрх, үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай ГХЯамны байр суурь - Бүлгийн ажил: Гол оролцогч талуудад хүргэх зөвлөмж	• В.Оюу Гадаад харилцааны яам Хүний эрхийн хэлтэс

Өдөр 3, 11-р сарын 14			
09:00 – 10:45	Нөөц бололцоог дайчлах сургалт <ul style="list-style-type: none"> - Идэвхжүүлэгчээс байгаа нөөц бололцоог олж харахын тулд оролцогч талууд/доноруудыг зураглах (сан, ур чадвар, хугацаа, туршлага гэх мэт) танилцуулга хийнэ. 	Идэвхжүүлэгч: П. Түвшинжаргал (МОНЭС)	
10:45 - 11:00	Цайны завсарлага		
11:00 – 12:30	Нөөц бололцоог дайчлах сургалт Бүлгийн ажил: Оролцогч талууд/хандивлагчдын зураглал (сан, ур чадвар, хугацаа ба туршлага г.м.)	Хэвлэлийн хурал -Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх талаарх зөвлөмжүүдийг танилцуулах -НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаг бичгийн Монгол хэл дээрх орчуулгатай зурагт хуудсыг танилцуулах -Ахмад настнуудын эрхийн талаар хэлэлцүүлэх/ ХЭХТ-өөс ахмад настнуудын эрхийн талаар гаргасан танилцуулга материалуудыг танилцуулах	Идэвхжүүлэгчид: Нөөц дайчлах: Түвшинжаргал үргэлжлүүлнэ. Хэвлэлийн хурал: Х.Наранжаргал (ГИ) -Зөвлөмжийг цуглааны оролцогч -Зурагт хуудсыг Бенни Агус Прима (ФА) -Ахмадын эрхийн тухай брошюр Г.Уранцоож (ХЭХТ) Урилга илгээх: ТББ Хэвлэл мэдээллийн байгууллагууд НҮБ-ийн агентлагууд
12:30 – 13:30	Өдрийн хоол		
13:30 – 15:30	Нөөц бололцоог дайчлах сургалт – үргэлжлэл <ul style="list-style-type: none"> - Хөрөнгө босгох, санал бичих практик зөвлөгөө / үндэсний, бүсийн болон олон улсын санхүүжүүлэгчидтэй холбоо тогтоох 	Идэвхжүүлэгч: П. Түвшинжаргал (МОНЭС)	
15:30 - 15:45	Цайны завсарлага		
15:45 – 16:15	Хүний эрхийг хамгаалагчдын үндэсний сүлжээний төслийн санал дээр ажиллах, санал боловсруулах <ul style="list-style-type: none"> - ХЭХТ/ГИ/ФА төслийн саналыг танилцуулна - Санал авах 	Идэвхжүүлэгч: П.Түвшинжаргал (МОНЭС) Г.Уранцоож (ХЭХТ)	

16:15 – 17.30	<p>Нөөц бололцоог дайчлах төлөвлөгөө, 2019-2020</p> <ul style="list-style-type: none"> - 2017 оны хэлэлцүүлэг, ажлын төлөвлөгөөнд суурилан ирэх хоёр жилийн шинэчилсэн төлөвлөгөө, шаардагдах нөөц бололцоог дайчлах төлөвлөгөөг хэлэлцэнэ 	<p>Идэвхжүүлэгч: Г.Уранцоож (ХЭХТ)</p>
17:30 - 18:00	Дүгнэлт, хаалт	ФА, ГИ, ХЭХТ
Өдөр 4, 11-р сарын 15		
11:00 – 13:00	<p>Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн орчин, бизнес ба хүний эрхийн асуудлаар иргэний нийгмээс гаргасан зөвлөмжүүдийг бусад талуудад танилцуулан хамтарч ажиллах боломжийг хэлэлцэх уулзалт 1.</p> <ul style="list-style-type: none"> - Улс төрийн намууд, судалгааны институт, Хүний эрхийн Дэд Хороо, Төрийн албан тушаалтнууд (ХЗДХЯ) 	<p>Идэвхжүүлэгч: Х.Наранжаргал (ГИ) Г.Уранцоож (ХЭХТ)</p>
13:00 –14 :00	Өдрийн хоол	
14:00-16:00	<p>Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хүний эрхийг хамгаалагчдын эр зүйн орчин, бизнес ба хүний эрхийн асуудлаар иргэний нийгмээс гаргасан зөвлөмжүүдийг бусад талуудад танилцуулан хамтарч ажиллах боломжийг хэлэлцэх уулзалт 2.</p> <ul style="list-style-type: none"> • Элчин Сайдын Яамд • Олон улсын хөгжлийн байгууллагууд 	